

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2007 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч  
С.Батдэлгэр

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

Монгол Улсын Дээд шүүх 2007 онд Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, шүүхийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлөөр хангах, шүүгч, ажилтнуудын сахилга, хариуцлага, ёс зүй, ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг дээшлүүлэх, шүүгчдийн эрх ашгийг хамгаалах, шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, шүүхийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулах, шүүхийн менежментийг боловсронгуй болгох, шүүгч ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг асуудлуудад анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ.

Улиран өнгөрч буй 2007 он ажил хөдөлмөрийн өрнүүн, амжилт бүтээлээр арвин жил байлаа.

Шүүгч, ажилтнуудын хөдөлмөр, зүтгэлийг Монголын төр өндрөөр үнэлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч А.Доржготов, Д.Тунгалаг нарыг “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор, Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайханыг “Алтангадас” одонгоор, шүүгч Б.Ундрах, Санхүү, хангамж, үйлчилгээний албаны дарга С.Баасанцэрэн нарыг “Хөдөлмөрийн хүндэт” медалиар тус тус шагнагдлаа.

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэрийг АНУ-ын Муж улсуудын шүүхийн үндэсний төвөөс Гарамгай зүтгэлтний шагналаар шагнасан байна.

Улсын Дээд шүүхийн Ахмадын зөвлөлөөс гаргасан санал, хүсэлтийн дагуу Улсын Дээд шүүхийн Ахмадын зөвлөлийн гишүүн Д.Цэрэнбалтав, Ө.Пүрэв, С.Баасансүх, Д.Минжүүр нарыг Зэвсэгт хүчний 86 жилийн ойн баярыг тохиолдуулан “Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн Хүндэт медаль”-иар, жолооч Г.Батчулуун “Шүүхийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр тус тус шагнуулав.

Түүнчлэн Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжил, шинэчлэлтэд болон шүүхийн хүний нөөцийг бэлтгэн бэхжүүлэх, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж буй бодит хувь нэмрийг үнэлж ЦЕГ-ын дарга асан, хошууч генерал Д.Сандаг-Очир, ШШГЕГ-ын дарга Д.Батжаргал, МУИС-ийн ХЗДС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн эрхлэгч Т.Мөнхжаргал, Нийслэлийн шүүхийн шүүгч Л.Даваасүрэн, Үндсэн хуулийн цэцийн дэд дарга Н.Жанцан нарыг Улсын Дээд шүүхийн “Хүндэт тэмдэг”-ээр, Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгч Н.Гачмаа, Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүхийн шүүгч Т.Байгалмаа, Архангай аймгийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга Ч.Ууж нарын 6 хүний Улсын Дээд шүүхийн “Жуух бичиг”-ээр тус тус шагналаа.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын тэргүүнүүд болон шүүгчид Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах Засгийн газар, Улсын Их Хурлын ажлын хэсэгт орон ажиллаж байна.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч 1 дүгээр сарын 26-ны өдөр 1/379 тоот албан даалгавраар бүх шатны шүүхийн шүүгч, ажилтнуудад хандан шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, шүүгч ажилтнуудын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн зарчмыг чанд мөрдөн ажиллах, шүүхийн болон эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлийг тууштай хийх замаар хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шудрага ёсны баталгаа болсон, орчин үеийн, дэлхийн жишигт нийцэхүйц шүүх эрх мэдлийн байгууллагыг төгөлдөржүүлэн бүрдүүлэх эрхэм зорилтыг

хэрэгжүүлэхэд шүүгч, ажилтнуудын хүчин зүтгэл чухал гэдгийг тэмдэглээд, хамтын хүчээр хийж бүтээсэн ажлуудыг дурьдаж, цаашид баримтлан ажиллах бодлого, чиглэлээ тодорхойллоо.

Улсын Дээд шүүх 2007 онд **86** ажил төлөвлөснөөс нь **73** нь бүрэн биелэж, **7** нь тодорхой шалтгааны улмаас хийгдэлгүй, **5** нь хойшлогдож, тасалдсан ажилгүй байна. Тухайлбал:

Улсын Их Хурлаас Эрүү, Иргэн, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд батлагдаагүй, мөн энэ шалтгаанаар Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар сургалт зохион байгуулах, АНУ-ын Техас муж улсын Уэслианы их сургуультай хамтран АНУ-д зохион байгуулах сургалт, Филиппин Улсад зохион байгуулагдах Шүүх, хуулийн байгууллагуудын хуралд төлөөлөгчдийг оролцуулах, Сингапур улсын Ерөнхий шүүгч Чан Сек Кеонгийг урих, Малайз улсын Ерөнхий шүүгч Тун Датос Шри Ахмад Файриз бин Датос Шейх Абдул Халимийг урих ажлууд тодорхой шалтгааны улмаас хэрэгжсэнгүй.

Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбарыг Ханнс-Зайделийн сантай хамтран гаргах, хэвлүүлэх, нийтэд тараах, сурталчлах, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах, Олон улсын гэрээг шүүхийн практикт хэрэглэх тухай тайлбар болон Ашигт малтмалын тухай хуулийн зарим зүйл, заалтын тайлбарлах тайлбарууд, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарыг гаргах ажлууд хойшлогдсон байна.

**“Шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн төв”** нь шүүхийн үйл ажиллагааны болон нийгэмд дуулиан тарьж буй хэргийн талаар Улсын Дээд шүүх, Нийслэл, дүүргийн шүүхүүд хамтран хэвлэл, мэдээллийн байгууллагуудад нийт ... удаа мэдээлэл хийлээ.

**“Улсын Дээд шүүхийн Вэб сайт”**-д тус шүүхийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, тогтоол, шүүх хуралдааны зар, хэрэг хянан шийдвэрлэлтийн байдал зэргийг тухайн долоо хоногт гаргаж хэвшлээ.

Мөн Улсын Дээд шүүхийн Вэб сайтыг англи хэл дээр хөрвүүлэн оруулж, гадаад дотоодын иргэд, байгууллагуудад ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Эрх зүйн мэдээллийг олон нийтэд нээлттэй, түргэн шуурхай хүргэх, эрх зүйн хэм хэмжээний уялдаа холбоог сайжруулах зорилгоор Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, Дотоод хэргийн сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын хамтарсан захирамж, тушаалаар “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн ажиллуулах журам”-ыг батлан гаргаж, хэрэгжүүлж, уг нэгдсэн санд Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолыг ёсчлогдсоноос нь хойш ажлын 5 өдрийн дотор оруулж хэвшүүлээд байна.

Шүүхийн 2006 оны ажлын тайланг ном болгон хэвлүүлж, нийтийн хүртээл болголоо. Мөн Улсын Дээд шүүхийн болон Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тухай танилцуулгыг англи хэл дээр хэвлүүлэн гаргалаа.

**“Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”**-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас **“Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг”**-ийг 2006 оны байдлаар гаргуулан авч, Улсын Дээд шүүхийн 17 шүүгчийн материалыг Авлигатай тэмцэх газар хүргүүлж, Захиргааны албан хаагч 44 хүний материалыг Улсын Дээд шүүхийн Тамгын газарт хадгалж байна.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын шилжилт, хөдөлгөөний тайланг компьютерийн шинэчлэсэн программын дагуу гарган Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлээ.

2007 оны 2 дугаар сарын 1-ний өдөр Шүүгчдийн зөвлөл хуралдаж, ШЕЗ-ийн гишүүнээр анхан шатны шүүхээс Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч А.Энхбаатар, давж заалдах шатнаас Сэлэнгэ аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Л.Баяраа, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч Д.Дамдиндорж нарыг сонгов.

Мөн хурлаар Шүүхийн мэргэжлийн хороо болон Сахилгын хороо, Шүүгчдийн холбооны 2006 оны ажлын тайланг хэлэлцсэн.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны дүн мэдээ гарч, Танхимууд, Тамгын газрын тайлан гарлаа. Ингээд Дээд шүүхийн 2007 оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.

### **Нэг. Шүүн таслах ажиллагааны талаар**

Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдааныг **14** удаа зарлан, нийт **14** өдөр хуралдуулж, бүгд **56** асуудал хэлэлцэж, **51** тогтоол, **5** тэмдэглэл гаргасны дотор, эрүүгийн **20**, иргэний **2**, захиргааны **1** хэрэг, хуулийн тайлбар **23**, аймгийн шүүхийг шалган тусласан дүнгийн тухай **5** тэмдэглэл, Нийслэлийн давж заалдах шатны болон дүүргийн анхан шатны шүүхийг шалган тусласан дүнгийн тухай **1** тогтоол, бусад **4** асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоо **6** -аар, хуулийн тайлбар **4** -өөр, иргэний хэрэг **2**-оор тус тус **буурч**, эрүүгийн хэрэг **3**-аар **нэмэгдэжээ**.

### **Эрүүгийн хэргийн танхим**

Эрүүгийн хэргийн танхим 2007 оны 12 дугаар сарын 21-ний байдлаар хяналтын журмаар эрүүгийн **736**, цагаатгалын **15**, нийт **751** хэрэг хүлээн авч, түүний **98.1** хувь буюу эрүүгийн **736**, **1.9** хувь буюу цагаатгалын **15** хэргийг хянаж шийдвэрлэсэн байна.

**Хяналтын журмаар** Танхимын тэргүүн Д.Батсайхан **138**, Б.Доржготов **137**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **132**, С.Нямжав **120**, Ч.Ганбат **115** Ерөнхий шүүгчийн ажлын алба **108** эрүүгийн хэрэг хүлээж авсан ба **543** эрүүгийн хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **171** эрүүгийн хэргийг хянан буцааж, одоо эрүүгийн хэргийн танхимд **24**, Ерөнхий шүүгчийн ажлын албанд **7** хэргийн үлдэгдэлтэй байна.

**Хяналтын шатны** эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **488**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **501**, Б.Доржготов **466**, шүүгч Ч.Ганбат **413**, С.Нямжав **347** удаа тус тус оролцсоноос;

Танхимын тэргүүн Д.Батсайхан **401**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **19**, Ч.Ганбат **40**, Б.Доржготов **30**, С.Нямжав **22** хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;

Танхимын тэргүүн Д.Батсайхан **87**, Б.Доржготов **128**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **116**, С.Нямжав **107**, Ч.Ганбат **105** хэрэг тус тус **илтгэсэн** байна.

**Эрүүгийн хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаан нийт **73** өдөр хуралдаж, **өдөрт 7.4** хэрэг хэлэлцэж, бүгд **543** хэрэг хянан шийдвэрлэсний **97.2** хувь буюу **528** нь эрүүгийн, **2.8** хувь буюу **15** нь цагаатгалын хэрэг байв.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн эрүүгийн **543** хэргийн **58.5** хувь буюу **318** тогтоол, магадлалыг **хэвээр үлдээж**, гомдол эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгосон бол **18.1** хувь буюу **98** нь **өөрчлөгдөж**, **23.4** хувь буюу **127** хэргийн тогтоол, магадлалыг **хүчингүй болгосон** байна.

Өөрчлөгдсөн **98** тогтоол, магадлалын **54.1** хувь буюу **53** нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **7.1** хувь буюу **7** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **1.02** хувь буюу **1** нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **3.06** хувь буюу **3** нь хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, **22.4** хувь буюу **22** нь шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **127** тогтоол, магадлалтай хэргээс **73** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, **31** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **12** хэргийг **хэрэгсэхгүй** болгож, бусад буюу шийтгэх тогтоол, магадлалын зарим заалт, хэсгийг хүчингүй болгосон **8** хэрэг байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **15** цагаатгалын хэргийн **33.3** хувь буюу **5**-д нь хэлмэгдэгсдийн овог, нэрийг өөрчилж, үлдэх **66.7**

хувь буюу **85** хүнд холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгажээ.

Улсын Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар эрүүгийн **20** хэрэг хянан хэлэлцэгдсэний **5** нь Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, **15** нь цаазаар авах ялтай хэрэг байв.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **86.8** хувь буюу **625** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн гомдлоор, **8.8** хувь буюу **64** нь яллагчийн эсэргүүцлээр, **4.4** хувь буюу **31** нь прокурорын дүгнэлтээр хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **51**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **12**, Ч.Ганбат **1**, Б.Доржготов **8**, С.Нямжав **3** хэргийг тус тус хянан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн эсвэл гомдол гаргах хугацаа хэтэрсэн хэргүүдийг дахин нягтлуулахаар, Ерөнхий шүүгчийн ажлын алба **96** хэргийг хянан зохих хариу өгөх байдлаар тус тус буцаасан байна.

Тус танхим 2007 онд нийт **243** өргөдөл, гомдол, албан бичиг хүлээн авснаас Танхимын тэргүүн Д.Батсайхан **240**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **6**, Ч.Ганбат **7**, Б.Доржготов **5**, С.Нямжав **1** өргөдлийг тус тус хянан шийдвэрлэж, одоо **3 албан бичгийн** үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **29** удаа оролцсоноос **2** удаа шүүх хуралдааныг даргалж, Б.Доржготов **31**, Ч.Ганбат **26**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **24**, С.Нямжав **1**, **захиргааны** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **23**, Ч.Ганбат **47**, Б.Доржготов **36**, шүүгч Б.Бат-Эрдэнэ **35**, С.Нямжав **15** удаа тус тус оролцож, Танхимын тэргүүн Д.Батсайхан **3** удаа шүүх хуралдааныг даргалжээ.

### **Иргэний хэргийн танхим**

Иргэний хэргийн танхим иргэд, байгууллагаас нийт ... өргөдөл, гомдол хүлээн авч, ... -г нь буюу ... хувийг шийдвэрлэжээ. Үүнд: Танхимын тэргүүн Ц.Амарсайхан ... шүүгч Д.Тунгалаг ... А.Доржготов ... Л.Бямбаа ... Б.Ундрах ... -ыг тус тус хянан шийдвэрлэж, одоо ... өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Энэ онд тус танхим өмнөх оны үлдэгдэл **33** хэрэг дээр **хяналтын журмаар** нийт **732** хэрэг шинээр хүлээн авч, нийт **765** хэргээс иргэний **707** хэргийг **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, дүгнэлт гаргуулахаар гомдол гаргасан **166** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, **40** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж шийдвэрлэжээ. Одоо хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх **18**, Ерөнхий шүүгчид дүгнэлт гаргуулахаар гомдол гаргасны дагуу хянагдаж байгаа **10** хэргийн үлдэгдэлтэй байна.

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **76** хэрэг хүлээн авч, **74** хэргийг **шийдвэрлэж**, үүнээс **59** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч А.Доржготов **174** хэрэг хүлээн авч, **170** хэргийг шийдвэрлэж, үүнээс **167** хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Шүүгч Л.Бямбаа **174** хэрэг хүлээн авч, **170** хэргийг шийдвэрлэж, үүнээс **162** хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлжээ.

Шүүгч Б.Ундрах **173** хэрэг хүлээн авч, **171** хэргийг шийдвэрлэж, үүнээс **166** хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

Шүүгч Д.Тунгалаг **168** хэрэг хүлээн авч, **162** хэргийг шийдвэрлэж, үүнээс **153** хэргийг хуралдаанд илтгэж шийдвэрлүүлсэн;

**Иргэний хэргийн хяналтын** шатны шүүх хуралдаан **64** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **11** хэрэг хэлэлцэн, нийт **707** хэрэг хянаж шийдвэрлэжээ.

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **678** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос 59** хуралдааныг,

Шүүгч Б.Ундрах **652** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос **23** хуралдааныг,

Шүүгч Л.Бямбаа **627** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос, **9** хуралдааныг,

Шүүгч А.Доржготов **609** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос, **21** хуралдааныг,

Шүүгч Д.Тунгалаг **557** хэрэг шийдвэрлэхэд оролцсоноос, **16** хуралдааныг тус тус **даргалжээ**.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **1** удаа даргалж, **13** шүүх хуралдаанд оролцсон бол шүүгч Б.Ундрах **38**, Д.Тунгалаг **26**, Л.Бямбаа **20**, А.Доржготов **9** шүүх хуралдаанд оролцсон байна.

Захиргааны хэргийн танхимын **хяналтын** шатны шүүх хуралдааныг Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **1** удаа даргалж, **18** хуралдаанд оролцсон, шүүгч Л.Бямбаа **39**, Б.Ундрах **28**, Д.Тунгалаг **27**, А.Доржготов **25** хуралдаанд тус тус оролцжээ.

Захиргааны хэргийн **давж заалдах** шатны шүүх хуралдаанд шүүгч А.Доржготов **4**, Б.Ундрах **1**, Д.Тунгалаг **1** удаа тус тус шүүх хуралдаанд **оролцжээ**.

Иргэний хэргийн танхим 2007 онд Танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **438**-ыг гаргаснаас “гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” шүүгчийн захирамж **24**, “гомдол гаргаагүйд тооцох тухай” шүүгчийн захирамж **5**, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” шүүгчийн захирамж **159**, Танхимын тэргүүний “шүүх бүрэлдэхүүн томилох тухай” захирамж **239**, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” захирамж **8**, бусад захирамж **11** байна.

**Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам, Иргэний Хөдөлгөөн Нам /ИХ/, Хөгжлийн Хөтөлбөр Намыг** Улсын бүртгэлд тус тус бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон байна.

**Монголын Ногоон намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг 2 удаа, МАХН, Иргэний зориг намын дүрмийг** тус тус шинэчлэн бүртгэсэн.

**Монголын Ардчилсан холбоо хөгжлийн хөтөлбөр намыг** улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан байна.

Иргэний хэргийн Танхим 2007 онд “**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй**” тайлбар ном, “**Иргэний хуулийн тайлбар**” номыг тус тус гаргасан байна.

### **Захиргааны хэргийн танхим**

Захиргааны хэргийн танхим 2007 онд **давж заалдах журмаар ... хяналтын журмаар ...** бүгд ... хэрэг хүлээн авчээ.

**Давж заалдах** журмаар ирүүлсэн захиргааны хэргээс ... -г нь шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, ... хэргийг хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэн, одоо ... хэргийн үлдэгдэлтэй байна.

**Хяналтын** журмаар ирүүлсэн захиргааны хэргийн ... нь Ерөнхий шүүгчид, ... нь шүүхийн шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч хяналтын журмаар, ... нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас гаргасан гомдол байв.

Хяналтын журмаар ирүүлсэн ... захиргааны хэргээс ... -г нь шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, ... хэргийг хуралдаанд оруулахгүйгээр шийдвэрлэж, одоо хяналтын журмаар хянагдах ... хэргийн үлдэгдэлтэй байна.

Танхимын тэргүүн О.Зандраа хяналтын журмаар ... хэрэг хүлээн авснаас, хяналтын шатны шүүх хуралдаанаар ... хэрэг;

Шүүгч П.Цэцгээ давж заалдах журмаар ... хяналтын журмаар ... хэрэг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар ... хяналтын шатны шүүх хуралдаанаар ... хэрэг;

Шүүгч Л.Атарцэцэг давж заалдах журмаар ... хяналтын журмаар ... хэрэг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар ... хяналтын шатны шүүх хуралдаанаар ... хэрэг;

Шүүгч Ч.Тунгалаг давж заалдах журмаар ... хяналтын журмаар ... хэрэг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар ... хяналтын шатны шүүх хуралдаанаар ... хэрэг;

Шүүгч Д.Пунцаг давж заалдах журмаар ... хяналтын журмаар ... хэрэг хүлээж авснаас давж заалдах шатны шүүх хуралдаанаар ... хяналтын шатны шүүх хуралдаанаар ... хэрэг тус тус илтгэж шийдвэрлүүлжээ.

Давж заалдах шатны шүүх хуралдааныг ... хяналтын шатны шүүх хуралдааныг ... өдөр тус тус хийж, өдөрт дунджаар ... хэрэг хэлэлцэн, нийт ... хэргийг хянан шийдвэрлэжээ.

Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа ... удаа оролцсоноос ... шүүгч Ч.Тунгалаг ... удаа оролцсоноос ... шүүгч П.Цэцгээ ... удаа оролцсоноос ... шүүгч Д.Пунцаг ... удаа оролцсоноос ... шүүгч Л.Атарцэцэг ... удаа оролцсоноос ... хуралдааныг тус тус даргалсан байна.

Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүх хуралдаанд шүүгч П.Цэцгээ ... удаа оролцсоноос ..., Л.Атарцэцэг ... удаа оролцсоноос ... Д.Пунцаг ... удаа оролцсоноос ... Ч.Тунгалаг ... удаа оролцсоноос ... хуралдааныг тус тус даргалжээ.

Ерөнхий шүүгчид гомдол гарган ирүүлсэн хэргүүдээс Танхимын тэргүүн О.Зандраа ... хэргийг Нийт шүүгчдийн хуралдаанаар илтгэн хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна.

Хяналтын шатны **эрүүгийн** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа ... удаа оролцсоноос ... шүүгч Д.Пунцаг ... удаа оролцсоноос ... Л.Атарцэцэг ... удаа оролцсоноос ... П.Цэцгээ ... удаа оролцсоноос ... Ч.Тунгалаг ... удаа оролцсоноос ... хэргийг тус тус илтгэж шийдвэрлэсэн байна. Танхимын тэргүүн О.Зандраа ... шүүгч Л.Атарцэцэг, Д.Пунцаг, Ч.Тунгалаг нар тус бүр ... удаа эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг даргалжээ.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн О.Зандраа ... удаа оролцсоноос ... шүүх хуралдааныг даргалж, шүүгч Д.Пунцаг ... П.Цэцгээ ... Л.Атарцэцэг ... Ч.Тунгалаг ... удаа тус тус оролцжээ. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлттэй ... иргэний хэргийг Захиргааны хэргийн танхимын шүүгч нар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсний ... хэргийг шүүгч Л.Атарцэцэг, ... хэргийг шүүгч Д.Пунцаг тус тус илтгэсэн байна.

2007 онд Захиргааны хэргийн танхим шүүгчийн захирамж ...-ыг гаргаснаас гомдол гаргаагүйд тооцох тухай ... шүүх хуралдааныг хойшлуулах тухай ... захирамж, шүүхийн тогтоол ... гаргаснаас гомдол гаргаагүйд тооцох тухай ... шүүх хуралдааныг хойшлуулах тухай ... шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас гаргасан хүсэлтийг хангахаас татгалзах тухай ... шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх тухай ... шүүхийн тогтоол байна. Танхимын тэргүүн нийт ... захирамж гаргаснаас ... нь шүүх бүрэлдэхүүнийг томилох тухай, ... нь харьяалал тогтоох тухай, ... нь захиргааны хэргийг шижүүлэх тухай захирамж байв.

Захиргааны хэргийн танхимд нийт ... байгууллага, албан тушаалтнаас албан бичиг ирүүлсэнд Танхимын тэргүүн болон шүүгч нар зохих хариуг албан бичгээр өгч, Танхимын тэргүүн О.Зандраа ... иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэжээ.

### **Хоёр. Мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны талаар**

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн арга зам нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулах, хуулийг нэг мөр ойлгон, зөв хэрэглэх талаар хуулийн албан ёсны тайлбар гаргах, шүүх, шүүгчдийн ажлыг шалган туслаж, тэдний дунд сургалт зохион байгуулах явдал юм.

Тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүх хуулийн зүйл, заалтыг тайлбарласан нийт **23** тайлбар гаргаж, “Дээд шүүхийн мэдээлэл”, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдэд нийтлүүлж, олон нийтийн хүртээл болголоо. Үүнд:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Л.Атарцэцэг/
2. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Д.Пунцаг/
3. Онцгой албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч Ч.Тунгалаг/
4. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Шүүгч П.Цэцгээ/

5. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /*Танхимын тэргүүн Ц.Амарсайхан*/
6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тайлбарлах тухай /*Шүүгч Ч.Тунгалаг*/
7. Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч Ч.Тунгалаг*/
8. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч П.Цэцгээ*/
9. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч П.Цэцгээ*/
10. Боловсролын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч Л.Атарцэцэг*/
11. Хоршооны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч А.Доржготов*/
12. Компанийн тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч А.Доржготов*/
13. Иргэний зарим хэргийн харьяаллыг захиргааны хэргийн харьяаллаас зааглан ялгах тухай /*Танхимын тэргүүн Ц.Амарсайхан, О.Зандраа*/
14. 2007 оны 8 дугаар сарын 9-ний Улсын Их Хурлаар батлагдсан Эрүүгийн Байцаан Шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл, заалтыг хэрэглэх журмын тухай /*Шүүгч Б.Бат-Эрдэнэ, Б.Доржготов*/
15. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүхийн практикт дагаж мөрдөх журмын тухай /*Танхимын тэргүүн Ц.Амарсайхан*/
16. Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлүүдийн зарим заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч Б.Бат-Эрдэнэ, Б.Доржготов*/
17. Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэрэг болон захиргааны зөрчлөөс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар /*Шүүгч Б.Доржготов*/
18. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч Б.Ундрах*/
19. Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч Л.Бямбаа*/
20. Захиргааны хариуцлагын тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай /*Танхимын тэргүүн Ц.Амарсайхан*/
21. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /*Шүүгч Д.Пунцаг*/
22. Эрүүгийн хуулийн 136 дугаар зүйлийг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай /*Шүүгч Д.Батсайхан*/
23. Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлийг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай /*Шүүгч Ч.Ганбат*/

Эдгээр тайлбарууд нь энэ төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний асуудлаар гарч байсан хүндрэл бэрхшээл бүрэн арилж, зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах иргэдийн баталгаа өсгөж, нийгмийн олон талт харилцааг хуулийн хүрээнд зохицуулах, хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд зохих хувь нэмэр оруулж байгаа гэдэгт итгэл төгс байна.

Мөн 2004 оноос хойш Улсын Дээд шүүхээс гаргасан нийт тайлбаруудыг нэгтгэн тохимол ном болгон шүүхийн шүүгч, ажилтнууд, прокурор, цагдаа гэх мэт шүүх эрх мэдлийн байгууллагын ажилласад болон судлаач, эрдэмтдийн хүртээл болгоход бэлэн болоод байгааг тэмдэглэхэд таатай байна.

Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхим **4** тойм, **3** зөвлөмж, иргэний хэргийн танхим **4** тойм, **4** зөвлөмж, захиргааны хэргийн танхим **4** тойм, **2** зөвлөмж, нийт **12** тойм, **9** зөвлөмж гарган шүүхүүдэд хүргүүлснээс гадна “Дээд шүүхийн Мэдээлэл” сэтгүүлд хэвлүүлээ.

Зөвлөмжүүдийг нэгтгэн эмхэтгэж, кодвикацижуулан нийт шүүхийн шүүгч, ажилтнуудын хүртээл болгох ажлыг эхлүүлэв.

Ерөнхий шүүгч С.Батдэлгэр танхимын тэргүүнүүд, Ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Тамгын газрын дарга нарын хамт Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл, Завхан, Архангай, Дорнод, Төв аймгуудын шүүхийн ажил байдалтай газар дээр нь очиж танилцан шүүгч, ажилтнуудтай уулзаж, шүүн таслах ажиллагааны чанар үр нөлөө, шүүгч, ажилтны ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ажлын зохион байгуулалт, дотоодын хяналт, шалгалтыг сайжруулах талаар үүрэг даалгавар өгч, тэдгээрийн санал бодол, хүсэлтийг сонсож, зарим асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэлээ. Ингээд Ерөнхий шүүгч сүүлийн 2 жилийн хугацаанд 21 аймгийн анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн ажил байдалтай танилцаж дууслаа.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүгчид Дундговь, Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн, мөн Нийслэлийн болон дүүргийн шүүхүүдийн ажлыг шалган туслаж, мэргэжлийн удирдлагаар хангаж, сургалт зохион байгууллаа.

Улсын Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаанаар Дундговь, Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудын шүүхийн ажлыг шалган тусалсан тухай асуудлыг хэлэлцэн **5 тэмдэглэл**, Нийслэлийн шүүх болон дүүргийн шүүхийн ажлыг шалган тусалсан тухай асуудлыг нэгтгэн хэлэлцэж **1 тогтоолыг** тус тус гарган холбогдох шүүхүүдэд нь хүргүүлжээ.

### **Гурав. Тамгын газрын ажлын талаар**

Тамгын газар нь Шүүхийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, шүүгч, ажилтнуудын хэвийн ажиллах нөхцлийг хангах, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх талаар анхааран ажиллаж иржээ.

Тамгын газрын даргын зөвлөл **6** удаа хуралдаж, уг зөвлөлийн хуралдаанаар Улсын Дээд шүүхийн жилийн эцсийн тооллогын дүн, тамгын газрын зарим ажилтнуудад чөлөө олгох, цалинг нь урьдчилан олгох, эрүүл мэндийн болон амьдралын хүнд байдал, ар гэрт нь хөрөнгө мөнгөний гачигдал тохиолдсон ажилтнууд, ахмадын зөвлөлийн гишүүдэд буцалтгүй тусламж олгох, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилгын зөрчил дутагдал гаргасан, ажил тасалсан зарим ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах зэрэг нийт **10** гаруй асуудлыг хэлэлцэн, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн шийдвэрлэжээ.

Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт ... тушаал гаргасан байна.

Улсын Дээд шүүх энэ онд нийт ... өргөдөл гомдол, ... албан бичиг, ... хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу компьютерт бүртгэн, бүртгэл хяналтын карт нээн, Ерөнхий шүүгчид танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хуваарилан өгч шийдвэрлүүлсэнээс гадна ... албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.

Ерөнхий шүүгч Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагчийг байлцуулан ... удаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч давхардсан тоогоор нийт **250** орчим хүнтэй биечлэн уулзаж, санал хүсэлтийг нь сонсон, зохих хариуг өгчээ.

Шүүх болон шүүгч нарыг мэргэжлийн удирдлагаар хангах, орон нутагт иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шүүгч, ажилтнуудынхаа ажиллах нөхцлийг сайжруулах талаар хийж байгаа ажлын талаар сар бүр мэдээлэл авч, Ерөнхий шүүгчид танилцуулж, улмаар уг мэдээллийг нэгтгэн нийт шүүхийн Ерөнхий шүүгч нарт хүргүүлж байгаа нь шүүхийн удирдлага бусад шүүхийн хийсэн ажлаас санаа авч ажлаа уялдуулан сайжруулахад зохих үр дүн өгч байна.

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба шүүх, шүүгчийн үйл ажиллагаатай холбоотой ... мэдээ, нийтлэл гарсныг бүртгэн, Ерөнхий шүүгчид тухай бүр нь танилцуулан холбогдох арга хэмжээг авч, үндэслэл муутай мэдээ, нийтлэлийг няцаах зорилгоор ... хариу тайлбар, залруулгыг өдөр тутмын сонинуудад нийтлүүлжээ.



Танхимын тэргүүнүүд “Шүүхийн 2007 оны эхний хагас жилийн ажлын дүн, явц байдлын талаар” хэвлэл, мэдээллийн 15 байгууллагын сэтгүүлч нарт мэдээлэл хийв. Энэхүү хэвлэлийн бага хурлалд Иргэний шүүн таслах ажлын зарим онцлог хэргийн шийдвэрлэлтийн талаар “ХЗХ-ны хэрэг, Зуучлах товчоо зэрэг олон нийтийн анхаарал татсан зарим хэргийн талаар” товч мэдээлэл хийсэн болно.

Нийслэлийн болон Захиргааны хэргийн шүүх, Дүүргийн шүүх, зарим аймгийн шүүхийн “Мэдээлэл, лавлагааны алба”-ны ажилтнуудын нэгдсэн бүртгэлийг шинэчлэх ажлыг зохион байгуулж 39 ажилтны бүртгэлийг шинээр хийв. ШЕЗ болон ХЗҮТөвтэй хамтран төслийн шугамаар “Мэдээлэл, лавлагааны алба”-ны ажилтнуудын нэгдсэн сургалтыг зохион байгуулахад оролцож хичээл заах, цаашид баримтлах бодлого, чиглэлээр гарын авлага тараах, дадлага хийхэд оролцсон болно. Дүүргийн шүүхэр явж тус албаны ажлын байрны нөхцөлтэй танилцах, ажлыг нь үзэх, санал солилцох, түүний мөрөөр ололт амжилтыг дэлгэрүүлэх, дутагдал доголдлыг арилгах арга хэмжээ авах талаар үүрэг даалгавар өглөө.

Шүүхийн байгууллага, шүүгч, ажилтнуудын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, доромжилсон, гүтгэсэн нийтлэлийн талаар хариу өгөх, шүүхэд нэхэмжлэл гаргах журмаар хамгаалах арга хэмжээг бодит ажил болгон хэрэгжүүлэх зорилгоор “Дорнод монгол” сонинд болон “Өдрийн сонин”-д Дорнод аймгийн шүүхийн нэр хүндэд сөрөгөөр нөлөөлөхүйц нийтлэл бичигдсэнд хариу болгож няцаалт хийсэн. Мөн “Өглөөний сонин”, “С-1” телевизээр-д “Зуучлах товчоо”-ны талаар гарсан Дээд шүүхийн шийдвэрийг мушгин гуйвуулж, гадаадад явахаар бүртгүүлсэн гэх 15.000 иргэнд буруу ойлголт өгөх мэдээлэл цацагдсанд шуурхай арга хэмжээ авч, хэд хэдэн сонинд мэдэгдэл гаргасан болно.

Мөн Архангай аймгийн Булган сумын ИТХ-ын дарга С.Мишка Архангай аймгийн шүүхийн үйл ажиллагааны талаар 15 удаа шүүхэд хандахад нэг удаа хариу өгөөгүй гэсэн шүүмжлэлийг “Нийгмийн толь” сонинд нийтлэгдсэн тул энэ талаар аймгийн шүүхээс нь лавлагаа авч өөрт нь хариу өгөхөд уучлалт хүссэн хариу ирсэн болно. Түүнчлэн “Алтандорнод” ХХК төлсөн татвараа Сангийн Яамнаас буцааж авахаар нэхэмжлэл гаргасаныг хэрэгсэхгүй болгосон Нийслэлийн шүүгч С.Өрнөндэлгэр, Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан нарыг шүүмжилсэн нийтлэлийг өдөр тутмын сонинд гаргасны хариу болгон “Алтны солиорол” гарчиг дор хариу бичиж хэвлэлүүдэд хүргүүлэв. Мөн Төрийн бус байгууллагаас ирүүлсэн 12 зүйл бүхий шаардлагад Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран мэдэгдэлийг 6 дугаар сард хийсэн болно. Үүнээс гадна “ОЛЛОО” вэб сайтад Дорноговь аймгийн Замын үүд дахь сум дундын шүүхийн шүүгч нарыг улсын хилээр алт гаргаж байгаад баригдсан мэтээр худлаа мэдээлэл тавигдсаныг залруулах ажлыг хийлээ.

Шүүхүүдийн тухайн сард хийсэн ажлыг шүүх нэг бүрээр нэгтгэн дүгнэж, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулах, цаашид авах арга хэмжээг төлөвлөн, нийт шүүхэд мэдээлэх ажлыг сар бүр хийж гүйцэтгэж ирлээ.

Шүүгч, ажилтануудтай сурвалжлагч нарыг уулзуулж, ярилцлага хийлгүүлэх, нийтлүүлэх зорилгоор Цагаатгалын ажил хариуцсан шинжээч М.Чойнямтой хоёр удаа ярилцлага хийлгүүлэн, “Нийгмийн толь” сонины энэ оны 9 дүгээр сарын дугаарт, “Зууны мэдээ” сонины 12 дугаар сарын дугаарт нийтлэгдсэн ба Хан-Уул дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Б.Баатар, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Д.Цогтсайхан: “Прокурор 15 жилийн ял оногдуулах ял санал оруулсан нь хууль зөрчсөн үйлдэл болсон /”Өдрийн сонин 2007-01-26 Баасан /’021//, Ц.Зориг: “Шүүхээс шалтгаалж, шүүх хуралдааныг хойшлуулсан явдал огт байхгүй” /Өдрийн сонин 2007-03-20 Мягмар /’064//, Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын Иргэний хэргийн шүүх хуралдаанаар Улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлтээ гаргасан “Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам”-ын асуудлыг хэлэлцэж, албан ёсоор улсын бүртгэлд бүртгэн авч гэрчилгээг нь гардуулан өгсөн талаарх ярилцлагыг нийтэлсэн болно /Өдрийн сонин 2007-02-09 Бямба /’033//, ШЕЗ-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Н.Ганбаярын “Шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр идэвхтэй ажиллана” /Өдрийн сонин 2007-02-12 Даваа/ нийтлэлийг тус тус хэвлүүлэн гаргалаа.

Байгууллагын захиалсан өдөр тутмын 8 сонинтой нэг бүрчлэн танилцаж хэвлэлийн тойм бэлтгэн Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүнүүдэд танилцуулж, тухай бүр анхаарах асуудлаар тодруулга хийж албан бичгээр хариу өгч байлаа.

Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран уулзалт ярилцлага зохион байгуулах ажил хийгдээгүй тасарсан болно.

Прокурор, Цагдаа, Өмгөөлөх байгууллагын хэвлэл, мэдээллийн асуудал хариуцсан ажилтануудтай ажил төрлийн уулзалт, ярилцлага, туршлага судлах, мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулах хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Байгууллагын номын санд ... ширхэг номыг худалдан авсны дотор Үндсэн хуулийн эрх зүйн ... Эрүүгийн эрх зүйн ... Иргэний эрх зүйн ... Хөдөлмөрийн эрх зүйн ... Олон Улсын эрх зүйн ... Төр эрх зүйн ... Монголын түүхийн ... Хүний эрхийн чиглэлийн ... болон бусад ном ... ширхэг байна.

Түүнээс гадна ... нэрийн ... ширхэг номыг “Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг”, “Соросын сан”, “Шүүх эрх зүйн шинэчлэлт төсөл”, “Олон улсын Барын холбоо”-ноос бэлэглэлээр авчээ.

Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн нь **2006** оны баримтуудыг Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим, Тамгын газар, Шүүхийн судалгааны төвөөс 2007 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээн авч, “Байнгын хадгалах бүртгэл”-ийн дансанд ... “Түр хадгалагдах бүртгэл”-ийн дансанд ... нэгж болгон зохих дансуудад бүртгэн хайрцагласан байна.

**Ерөнхий шүүгчийн ажлын алба** “Улсын Дээд шүүхэд хэрэг болон иргэд, хуулийн этгээд, хэргийн оролцогчдоос гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, хуваарилах, шийдвэрлэх журам”, “Ерөнхий шүүгчийн ажлын албаны зорилт гүйцэтгэх үүрэг”-т заасны дагуу Ерөнхий шүүгчийн нэр дээр гаргасан гомдлоор эрүүгийн **100**, иргэний **166**, захиргааны **42 нийт 308** хэргийг хүлээн авч, эрүүгийн **3**, иргэний **1** хэргийн тогтоолд хууль зөрчсөн үндэслэлээр тус тус **дүгнэлт** бичиж, **84** хэрэгт хариу өгчээ.

Мөн хэргийн оролцогч **152** хүнийг хүлээн авч уулзаж, холбогдох хариуг өгсөн байна. Ерөнхий шүүгчийн ажлын албанаас албан бичиг **425**-ийг боловсруулж, байгууллага, иргэдэд явуулсан.

Тайлангийн хугацаанд Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах **Ж.Эрдэнэчимэг** Багануур дүүргийн шүүхийн, Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах **Н.Батзориг** Орхон аймгийн шүүхийн, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах **Б.Цогт** Чингэлтэй дүүргийн шүүхийн, Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах **С.Мөнхжаргал** Нийслэлийн Захиргааны хэргийн **шүүхийн шүүгчийн албан тушаалд** тус тус дэвшин томилогдож, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах **Ж.Халиун**, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагч **Ц.Цэцэгдэлгэрэх**, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **Ц.Нарангэрэл**, нар төрийн өөр байгууллага, албан тушаалд шилжин ажиллаж, Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **С.Одгариг**, жолооч **Б.Ганбаяр**, мужаан **Б.Энхээ**, Сантехникийн слесарь **А.Дашжамц**, **М.Лхагвасүрэн** нар өөрөө хүсэлтээ болон гэрээний хугацаа дууссан гаргасан тул ажлаас чөлөөлөгдөж, **Г.Гандмааг** Мэдээлэл, лавлагааны ажил хариуцсан мэргэжилтэн, **Б.Мягмаржавыг** Дотоод ажил, зохион байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтний, **О.Баттулгыг** Судалгааны асуудал хариуцсан ахлах шинжээчийн, **Ч.Цэндийг** Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагчийн, **Ц.Баярмааг** Эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээчийн, **Т.Майцэцэгийг** Дотоод ажил, зохион байгуулалтын асуудал хариуцсан мэргэжилтнээр, **И.Амартөгс**, **Л.Одончимэг** нарыг Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслахын, **Э.Баярбаатарыг** Компьютер техник хангамжийн асуудал хариуцсан референтийн, **Б.Эрдэнэбаярыг** Компьютер программ хангамжийн асуудал хариуцсан шинжээчийн, **Ч.Төмөрбаатарыг** Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээчийн, **М.Мөнхтөр**, **Г.Билгүүн** нарыг Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслахын, **Б.Цолмонбаатарыг** Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслахын, **Д.Оюунчимэгийг** Шүүхийн статистик, тоон мэдээлэл хариуцсан ахлах зааварлагчийн, **Г.Есөн-Эрдэнийг** Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслахын, **Ө.Уянгыг** Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслахын, **Э.Цог-Эрдэнийг** жолоочийн, **Д.Оюунчимэгийг** үйлчлэгчийн, **М.Мөнхбаярыг** мужааны ажил, албан тушаалд бүр болон түр хугацаагаар Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар томилон ажиллуулж байна.

Шүүхийн статистик, тоон мэдээлэл хариуцсан ахлах зааварлагч **С.Эрдэнэчимэг** өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөн гавьяаныхаа амралтанд гарлаа.

Компьютерийн техник хангамжийн асуудал хариуцсан референт **Д.Мөнхзориг** БНСУ-д, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах **Э.Амин-Эрдэнэ** Япон Улсад тус тус суралцахаар, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах **Б.Чимгээ** хүүхэд асрах урт хугацааны чөлөө авсан.

“Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу Улсын Дээд шүүхэд сул байгаа орон тоонд сонгон шалгаруулалт зарлаж, Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, **М.Дамирансүрэнг** Ерөнхий шүүгчийн ажлын албаны даргын, **Б.Цогнямыг** Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны даргын, **Ч.Нямсүрэнг** Шүүхийн судалгааны төвийн захирлын албан тушаалд тус тус томилон ажиллууллаа.

“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан болзлыг хангасан Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний туслах **Э.Амин-Эрдэнэ**, Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах **Ч.Отгонбаяр**, Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах **С.Мөнхжаргал** нарт “Ахлах түшмэл” ангиллын “АА-8” зэрэглэлийн “Гутгаар”, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах **Г.Есөн-Эрдэнэд** “Ахлах түшмэл” ангиллын “АА-8” зэрэглэлийн “Дөтгөөр” зэрэг дэвийг тус тус олгох шийдвэр гаргалаа.

“Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д заасан болзлыг хангасан Ерөнхий шүүгчийн туслах-ахлах шинжээч **И.Ганбат**, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах **Б.Цогт**, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах **Ч.Отгонбаяр**, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах **Г.Есөн-Эрдэнэ**, Захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах **М.Пүрэвсүрэн**, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **Б.Мөнхзул** нарын цалингийн шатлалын нэмэгдэл, Тамгын газрын дарга **Д.Эрдэнэчулуун**, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах **Ө.Уянга**, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах **Б.Чимгээ**, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагч **Ч.Цэнд** нарын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн олгохоор шийдвэрлэв.

“Төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д заасан болзлыг хангасан нярав **Б.Отгонцэрэн**, жолооч **Д.Мөнхнасан** нарын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн олгохоор шийдвэрлэв.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын биеийн эрүүл мэндийн байдал, ажлын ачаалал зэргийг харгалзан **эмч А.Ариунболортой** гэрээ байгуулж 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар ажиллуулж байна.

Шүүгч, ажилтнуудын хүүхдүүдээс гэр бүлээс их, дээд сургуульд 2007-2008 оны хичээлийн жилд суралцаж байгаа нийт 2 оюутны “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай” гэрээг Сургалтын төрийн сантай байгуулж, төлбөрийг нь төлжээ.

Ар гэрт нь гачигдал тохиолдсон шүүгч, ажилтан, Ахмадын зөвлөлийн гишүүн бүгд 39 хүнд нийт **3.772.952** төгрөгийн буцалтгүй тусламжийг олгожээ.

Тамгын газрын даргын 2005 оны 111 дүгээр тушаалаар батлагдсан “Халамжийн сан бүрдүүлэх, хадгалах, зарцуулах журам”-д заасны дагуу энэ онд давхардсан тоогоор 19 хүнийг эмнэлэгт эмчлүүлж байх хугацаанд нь **285.000** төгрөгөөр эргэж, ар гэрт нь гачигдал гарсан 2 хүнд тус бүр **100.000** төгрөгийн тусламж үзүүлсэн бөгөөд одоо уг санд **640.300** төгрөгийн үлдэгдэл байна. Оны эхэнд уг санд **345.800** төгрөгийн үлдэгдэл байсан ба энэ онд уг санд нийт **1.125.300** төгрөгийн орлого орсон байна.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудын дунд орон сууцны судалгаа явуулж, Улсын Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн удирдлагууд Улаанбаатар хотын банкны удирдлагуудтай харилцан тохиролцож, Улсын Дээд шүүхийн шүүгчид, Тамгын газрын болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 50 сая хүртэл төгрөгийн, 10 жилийн хугацаатай, жилийн 8 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлийг

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнууд нийт 39 хүнд олгох асуудлыг шийдвэрлэсэн билээ. Үүний дагуу манай зарим шүүгч, ажилтнууд уг зээлд хамрагдаж эхлээд байгаа нь баярлуштай.

Ойн баяр болон тэмдэглэлт өдрүүдэд Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор **3** удаагийн тушаалаар **7** хүнийг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллууллаа.

Ажлын сахилга хариуцлага алдсан, ажлын алдаа дутагдал гаргасан **2** ажилтанд Тамгын газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулж, **1** хүнийг ажлаас халсан байна.

Нийслэлийн Шүүх байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан 3 дугаар сарын 26-наас 31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Нийслэл, дүүргүүдийн шүүхүүдийн шилжин явах цомын төлөө тэмцээн"-д сагсан бөмбөг, гар бөмбөг, одон бөмбөгийн төрлөөр Улсын Дээд шүүх амжилттай оролцож, багийн дүнгээр **2** дугаар байр эзэллээ.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнууд "Хаврын баяр"-ыг тэмдэглэж, БХЯ-ны харьяа "Чингисийн хүрээ" амралтанд очив. Мөн "Ахмадын өдөр"-ийг тохиолдуулан ахмад үе залуу үеийн холбоо бэхжүүлэн, ахмад шүүгч, ажилтнуудын сургаалийг сонсож, Ахмадын зөвлөлийн гишүүдтэй хамтран нийт шүүгч, ажилтнууд "Хайртхан" амралтанд амрав.

"Бүгд Найрамдах улс" тунхагласны баярыг тохиолдуулан жил бүр хуулийн төв байгууллагуудын дунд зохиогддог "**Шилжин явах цомын төлөө спортын наадам**"-ыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулж, манай баг тамирчид амжилттай оролцож, багаараа **4** дүгээр байр эзлэв.

Онцгой байдлын ерөнхий газрын албан хаагчид 2007 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Сэлэнгэ аймгийн Мандал суманд албан үүргээ гүйцэтгэж яваад эрдэнэт амиа алдсан явдалд гүн эмгэнэл илэрхийлж, амь насаа алдсан албан хаагчдын ар гэрийнхэнд 300.000 /гурван зуун мянган/ төгрөгийг, ослын үеэр хүнд гэмтэл авсан ажилтнуудын эмчилгээний зардалд 300.000 /гурван зуун мянган/ төгрөгийг нийт 600.000 /зургаан зуун мянган/ төгрөгийг хандивыг хүргүүлсэн байна.

2007 онд Улсын Дээд шүүхийн төсөв ... сая төгрөгөөр, үүнээс урсгал зардалд ... сая төгрөг, их засварт ... сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад ... сая төгрөг тус тус батлагдсан билээ.

Урсгал зардлын батлагдсан төсвийг бүрэн авч, төсөвт тусган төсвийн зардлыг зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж ирлээ.

Урсгал зардлын төсвийг хэрхэн зарцуулсныг зүйл тус бүрээр нь танилцуулбал:

- Бичиг хэрэг, аж ахуйн зардалд 10 000.0 мянган төгрөг төлөвлөснөөс 13 000.0 мянган төгрөг зарцуулагдсан бөгөөд **3000.0** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Гэрэл цахилгааны зардалд **4669,7** мянган төгрөг төлөвлөснөөс **.8421,03** мянган төгрөг зарцуулагдаж, **3751,3** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Түлш, халаалтын зардалд **16232,5** мянган төгрөг төлөвлөснөөс **7409,06** мянган төгрөг зарцуулагдаж, мянган төгрөгөөр **хэмнэгдсэн**;
- Тээвэр, шатахууны зардалд **31686,9** мянган төгрөг төлөвлөснөөс **34,686,9** мянган төгрөг **зарцуулсан**;
- Шуудан, холбооны зардалд **26401,0** мянган төгрөг төлөвлөснөөс **23396,3** мянган төгрөг зарцуулагдаж, мянган төгрөгөөр **хэмнэсэн**;
- Цэвэр, бохир усны зардалд **1833,3** мянган төгрөг төлөвлөснөөс **649,18** мянган төгрөг зарцуулагдаж, ..... мянган төгрөг **хэмнэгдсэн**;
- Дотоод албан томилолтын зардалд **4755,4** мянган төгрөг төлөвлөснөөс **4622,03** мянган төгрөг зарцуулагдаж, ..... мянган төгрөгөөр **хэмнэсэн**;
- Гадаад албан томилолтын зардалд **7692,8** мянган төгрөг төлөвлөснөөс **7692,8** мянган төгрөг зарцуулагдаж, ..... мянган төгрөгөөр хэмнэсэн;
- Ном, хэвлэл авах зардалд **2110,2** мянган төгрөг төлөвлөснөөс **2110,0** мянган төгрөг зарцуулагдаж, ..... мянган төгрөгөөр хэмнэсэн;

- Нормын хувцас авах зардалд **127,5** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **127,5** мянган төгрөг зарцуулж ..... мянган төгрөг хэмнэсэн;
- Урсгал засварын зардалд 3646,0 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **3645,06** мянган төгрөг зарцуулагдаж, ..... **мянган** төгрөгөөр **хэтэрсэн**;
- Гадаад зочны зардалд **5100,0** мянган төгрөг төлөвлөснөөс **5095,9** мянган төгрөг зарцуулж .... мянган төгрөг хэмнэгдсэн;
- Ерөнхий шүүгчийн байрны зардалд **380,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс ..... мянган төгрөг зарцуулагдаж, ..... мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- 1 удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд **35257,6** мянган төгрөг төлөвлөснөөс мянган төгрөг зарцуулагдаж, ..... **мянган** төгрөгөөр **хэтэрсэн**;
- Төлбөр хураамж болон бусад зардалд 5667,8 мянган төгрөг төлөвлөгдснөөс **5666,0** мянган төгрөг зарцуулсан;
- Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд ..... мянган төгрөг төлөвлөснөөс ..... мянган төгрөг зарцуулагдаж, ..... мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Цалин хөлс, нэмэгдлийн зардалд ..... мянган төгрөг төлөвлөгдснөөс ..... мянган төгрөг зарцуулагдаж, ..... мянган төгрөг хэмнэгдсэн;
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд **12660,0** мянган төгрөг батлагдсанаас **12660,0** мянган төгрөг зарцуулагдаж, ..... **мянган** төгрөгөөр **хэтэрсэн**;
- Жижиг эд хогшил худалдан авах зардалд **3400,9** мянган төгрөг батлагдсанаас **3400,9** мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

“**Эрх зүйн боловсрол академи**”-д .... өрөөг түрээслэн нийт ..... төгрөгийн орлого олсноос Улсын Дээд шүүхийн конторын барилгын их засварын ажилд болон “Шинэ жил”, “Цагаан сар”, “Эмэгтэйчүүдийн баяр”, “Хүүхдийн баяр”, “Ахмадын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ зэрэгт зарцуулж, үлдэгдэл мөнгөгүй болсон байна.

Маркийн ... **сая** төгрөгийн үнэ бүхий автомашиныг ТӨХ-ны .... дүгээр тогтоолын дагуу ..... **шүүхэд**, .... дугаар тогтоолын дагуу ..... төгрөгийн үнэ бүхий ... ширхэг Dell маркийн компьютерийг ..... шүүхүүдэд балансаас балансад шилжүүлэн өглөө.

Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн, хяналт, давж заалдах шатны шүүх хуралдааны танхимуудад ярианы тоног төхөөрөмж суурилуулж, гэрэлтдэг диодон самбар байрлуулав. Мэдээлэл лавлаганы төвтэй шууд холбогдон шүүх хуралд ирсэн өмгөөлөгч, оролцогч нарыг хуралдааны нарийн бичиг гарч дууддаг байсан явдлыг болиулав. Нийт шүүгчдийн хуралдааны танхимд хуралдааны заалны аудио тоног төхөөрөмж суурилуулсан бөгөөд хуйлдаг удирдлагатай дэлгэц, прожектор, прожекторын шилэн тавиур, зөөврийн компьютер зэргийг шинээр авав.

Мөн Нийт шүүгчдийн хуралдааны танхимд болон Ерөнхий шүүгчийн өрөөнд Эйр кондиционер суурилуулсан.

Шүүгч нарын өрөөнд ажлын тав тухтай орчинг бүрдүүлэхийн тулд бүх шүүгчдэд хөргөгч, 14 инчийн өнгөт зурагт авч тавьж өгөв. Мөн “Сансар кабель” телевизийн шугамыг тавиулсан.

Мэдээлэл лавлагааны өрөөнд 19 инчийн LCD дэлгэц авч уг дэлгэц авч, уг дэлгэцээр иргэд болон хэргийн оролцогч нарт шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдээлэлийг үзүүлж байна.

Цахилгааны тэжээлийн кабель муудаж цахилгаан удаа дараа тасарч байсан тул 190 метр цахилгааны тэжээлийн кабелийг Инженер Энерги компианаар солиулж цахилгаан тоолуур тавиулсан.

Үйлчлэгч нарын өрөөнд хувцасны төмөр шкаф шинээр авсан.

Улсын Дээд шүүхийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 8 автомашиныг Улсын үзлэг тооллогонд хамаруулан тоолуулав. Мөн тендер зарлан 1 ш “Соната HF” автомашиныг Хьюндай-Киа моторс компианаас худалдаж авсан. Хуучин хэрэглэж байсан “Соната-5” автомашиныг Нийслэлийн Баян зүрх дүүргийн шүүхэд шүлжүүлэн хүлээлгэн өгөв.

“Шүүх эрх мэдлийн шинэтгэл хөтөлбөр” төслөөс Эрүүгийн хэргийн танхимд CANON маркийн IR 2016 хувилагчийг хүлээлгэн өгөв. Мөн БНХАУ-ын Элчин сайдын яамнаас хоёр орны

найрамдал, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж буйг үнэлж, DELL маркийн OPTIPLEX GX 620 компьютер бэлэглэснийг Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны даргад өгсөн.

Факсын аппарат, өнгөт принтер, Скайнер, тогбаригч, 16 портын свич, DVD бичигч, нот бук /леново/, диктафон, ноорог устгагч зэрэг техник тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан.

Хүлээлгийн сандал, эргэдэг сандал, хурлын ширээ /индэрийн/, тумбочик, уулзалтын өрөөний ширээ, сандал, номын шүүгээ, мөнгөний сейф, хивс, цонхны хөшиг, заалны цонхны хөшиг, вип заалны өрөөний тавилга /сандал, ширээ/ г.м эд хогшил, тавилгуудыг худалдан авч тавив.

Ланд 200 маркийн автомашиныг Хэт ХХК –с худалдан авсан. Нийтийн дуудлага худалдаагаар хуучин Делика автомашиныг худалдав.

Хөдөлмөрчдийг хүлээн авах өрөөг өөрсдийн хүч бололцоогоор засаж тохижуулав.

Байгууллагын дүнгээр ... төгрөгийн барилга байшин, ..... төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, ..... төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, аж ахуйн материал, ..... төгрөгийн үнэ бүхий 8 автомашин тоологдлоо.

### **Дөрөв. Шүүхийн судалгааны төвийн ажлын талаар**

***Хууль тайлбарын болон бусад баримт бичгийн төслийг боловсруулахад оролцох ажлын талаар:***

Улсын Дээд шүүхээс гаргадаг хуулийн тайлбар боловсруулах явцад дүн шинжилгээ хийх, холбогдох мэдээллийг нэгтгэн санал боловсруулах чиглэлээр холбогдох танхимтай хамтран ажилласан.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 50-53 дугаар зүйлийн онолын тайлбарт санал боловсруулж оролцсон.

***Шүүхээс хууль хэрэглэх практик судлах, нэгтгэн дүгнэх, тойм зөвлөмж боловсруулах талаар:***

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2007 оны эхний 3 улиралд хянагдсан бүх хэргийн тогтоол, магадлал өөрчлөгдсөн, хүчингүй болсон шалтгааныг судалсан тухай тоймуудыг танхимуудтай хамтран бэлтгэж хэвлүүлсэн.

“Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийг шийдвэрлэхэд тулгарч буй бэрхшээлтэй асуудал “судалгааны асуулгыг боловсруулж, УДШ, нийслэл, аймаг, дүүрэг, сум дундын шүүхүүдийн шүүгч нарын дунд явуулж судалгааны дүнгээр танилцуулга бэлтгэв.

Иргэний, Гэр бүлийн болон ИХШХШ тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн талаар нийслэл болон дүүргүүдийн шүүхүүдийн шийдвэрлэсэн хэрэгт дүн шинжилгээ хийсэн;

Улсын Дээд шүүхийн хуулийн норматив тайлбарын чанарын судалгааны нийслэл, дүүргийн нийт шүүхүүдийн шүүгч нарын дунд явуулж, үр дүнг нэгтгэх ажил хийж эхлүүлж, шүүхийн практик судлах социологийн судалгааны арга зүй, загварчлал боловсруулж, нэвтрүүлж эхлээд байна.

2007 оны 12 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд шийдвэрлэсэн “Байгаль хамгаалах журмын эсрэг” гэмт хэргүүдийн зүйлчлэлийн байдал, хэргийн тоон үзүүлэлт, уг гэмт хэрэгт холбогдогсдын ажил мэргэжлийн статистик судалгааг гаргав.

Захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаас хойш УДШ-ээр давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар хянагдсан хэргүүдийг судлаж нийгмийн даатгалын тухай хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүдийн шийдвэрлэсэн байдлыг нэгтгэн дүгнэж танилцуулга бичсэн.

Монгол Улсын Дээд шүүхийн Судалгааны төв, Хууль зүйн үндэсний төв хамтран “Монгол Улсын Дээд шүүхийн шийдвэрийн эмхтгэл” (Иргэний хэрэг) VII, (Эрүүгийн хэрэг) V, (Захиргааны хэрэг) ботийг гаргахаар төлөвлөж, III улиралаар дотор эрүү, иргэн, захиргааны хэргүүдийн шийдвэр, магадлал, тогтоолыг 21 аймаг, нийслэл, дүүрэг, сум дундын шүүхээс хуулбар болон болон цахим хэлбэрээр татан авч нэгтгэж хүргүүлсэн.

Захиргааны хэргийн шүүх байгуулагдсанаас хойш УДШ-ээр давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар хянагдсан хэргүүдийг судлаж Боловсролын тухай хуулиар шийдвэрлэгдсэн хэргүүдийн шийдвэрлэсэн байдлыг нэгтгэн судлаж танилцуулга бичсэн.

2007 оны эхний хагас жилийн байдлаар шүүхээр шийдвэрлэсэн Авилга хээл хахуулийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал, бүлэглэж хэрэг үйлдсэн ял шийтгүүлэгчдийн тоо, Шүүхээр шийдвэрлэсэн албан тушаалын гэмт хэрэг гэмт хэргийн талаарх мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд гаргасан.

### ***Эрх зүйн системчлэл, мэдээлэл, арга зүйн талаар:***

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт хийх хяналт шинжилгээ, үнэлгээний (мониторинг) шүүх эрх мэдлийн хүрээнд хийгдэх дэлгэрэнгүй багц судалгаа гаргах хуваарь гаргаж ШЕЗ болон бүх шатны шүүхүүдийн үйл ажиллагаатай 24 төрлийн томоохон судалгааг гаргаж Хууль зүй, дотоод хэргийн Яаманд хүргүүлсэн.

Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газраас манайд ирүүлж байгаа Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Төрийн мэдээлэл сэтгүүлүүдийг дугаар бүрээр хүлээн авч шүүгч, ажилтнуудад эх хувиар болон дотоод сүлжээгээр дамжуулан ашиглуулж лавлагаа өгч ажиллаж байна.

Улсын Дээд Шүүхийн Мэдээллийн “Нэгдсэн сан”-д: Монгол Улсын хуулиуд; Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол; Ерөнхий шүүгчийн захирамж; Монгол Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол; Эрүү, иргэн, захиргааны хэргийн танхим болон Судалгааны төвөөс гаргасан тойм зөвлөмж; шүүн таслах ажлын практик ач холбогдол бүхий хяналтын шатны эрүү, иргэн захиргааны болон нийт шүүгчдийн хуралдааны тогтоолуудыг өдөр тутам оруулан нэгдсэн санг баяжуулан ажиллуулж байна.

Монгол Улсын ИХ хурлын Тамгын газраас энэ онд Монгол Улсын 99 хууль хүлээн авснаас 63 хуульд нэмэлт, өөрчлөлтийг эх хууль болон Төрийн мэдээлэл сэтгүүлд байдаг хувьд тухай бүрт нь хийхийн зэрэгцээ компьютерт давхар өөрчлөлтийг оруулсан болно.

Улсын Их Хурлын тогтоол 91-ыг хүлээн авч, Мөн Улсын Их хурлын тогтоолын эх хувь болон төрийн мэдээлэл сэтгүүлд зохих өөрчлөлтийг тухай бүр нь оруулав.

Төрийн мэдээлэл сэтгүүлд хэвлэгдсэн Засгийн газрын 55 тогтоолд өөрчлөлт орсон болон хүчингүй болсонд тооцон тухай өөрчлөлтийг хийсэн байна.

Хууль тогтоомжийн лавлагааг давхардсан тоогоор 450 хүнд өгч, шүүгч, ажилтнуудын шүүн таслах болон албан ажлын хэрэгцээнд гарын авлага болгон ашиглуулж байна.

Шүүхийн нэгдсэн санд шинээр Улсын Дээд Шүүхийн хууль тайлбарласан тогтоол болон шүүх шалгасан дүнгийн тухай нийт 24 тогтоол, шүүн таслах ажиллагааны практик ач холбогдол бүхий эрүүгийн 62, иргэний 85, захиргааны 42 тогтоол, нийт шүүгчдийн хуралдааны 7 тогтоол, нийт 196 тогтоол, УДШ-ийн Ерөнхий шүүгчийн захирамж 6, тойм, зөвлөмж 13 -ийг орууллаа.

1998-2007 онуудын Засгийн Газрын тогтоолууд болон Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоол, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын захирамж болон нарийн бичгийн даргын тушаал зэрэг 40 гаруй тогтоол, захирамж, тушаалуудыг Мэдээллийн нэгдсэн санд оруулж, “Мэдээллийн нэгдсэн сан”-г улам боловсронгуй болгон өргөжүүллээ.

### ***Шүүхийн статистик, мэдээлэл зүйн ажлын талаар:***

Монгол Улсын төр, захиргааны төв байгууллагын болон нийт шүүхийн удирдлагыг шүүн таслах ажлын үнэн зөв мэдээллээр хангах зориулалтаар доорх судалгаа, танилцуулгыг гаргав.

1. Бүх шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны 2006 оны бүтэн жилийн шүүхийн статистик мэдээний улсын хэмжээний нэгдсэн дүнг гарган, танилцуулгыг УДШ-ийн удирдлага, МУ-ын Ерөнхийлөгч, Их хурлын дарга, Ерөнхий сайд болон бүх шатны шүүхүүдийн ерөнхий шүүгч нарт хүргүүлэн танилцуулсан. Мөн Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны тайлан номонд шүүн таслах ажлын тайлан, тоон үзүүлэлтийг бэлтгэх, нийтлүүлсэн.

2. Шүүхийн нэгдсэн санд 2006 оны бүтэн жилийн статистик мэдээний нэгдсэн дүнгийн талаарх судалгааг өгсөн.

3. 2007 оны I,II,III улирлын шүүн таслах ажиллагааны шуурхай мэдээг нэгтгэн гаргаж нийт шүүхүүд, УДШ-ийн удирдлага, танхимуудын хүрээнд танилцуулав.

Албан ажлын хэрэгцээнд зориулж шүүхийн статистикийн чиглэлээр дараах тоон судалгаануудыг гаргав.

1. Шүүхээр 2002-2006 онд насанд хүрээгүй хүмүүст оногдуулсан ялын байдлын судалгааг гаргаж Монгол Улсын Засгийн газарт;

2. 2006 оны Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу өршөөлд хамрагдсан хүмүүсээс дахин гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн хүмүүсийн судалгааг 2006 он, 2007 оны 5 сарын хугацаагаар гаргаж МУИХ-ын ХЗБХ-нд;

3. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй хүмүүсийн судалгааг 2002-2007 оны I улирлын байдлаар гаргаж ХЗДХЯ-нд;

4. Хээл хахууль авсан, өгсөн, зуучилсан гэмт хэргийг шүүхээр 2004-2006 онуудад шийдвэрлэсэн талаарх судалгааг Ерөнхий шүүгчийн ажлын албанд;

5. Анхан шат, Давж заалдах шатны шүүхийн шүүгч нарын ажлын дундаж ачааллыг 2003-2006 оноор гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлд;

6. Захиргааны хэргийн шүүхээр 2004-2006 онд шийдвэрлэсэн хэргийн судалгааг гаргаж Шүүхийн ерөнхий зөвлөлд;

7. ИХШХШ хуулиар шийдвэрлэсэн хэргийн судалгааг 2004-2006 онуудаар гаргаж Иргэний хэргийн танхимд;

8. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд нөхөн төлбөр олгох тухай хуулийн төсөлтэй холбоотой судалгааг нарийвчлан гаргаж Хууль зүй, Дотоод хэргийн яаманд;

9. 2002-2007 оны эхний хагас жилд нийт шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо, үүнээс гэр бүлийн маргаан шийдвэрлэсэн тоо, гэрлэлт цуцалсан тоог хүснэгтээр нарийвчлан Хууль зүйн үндэсний төвд;

10. Аймаг, нийслэлийн шүүхүүдээс эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр зохион байгуулах ерөнхий шүүгч нарын сургалтанд заалгах хичээлүүдийн сэдвүүдийг нэгтгэн гаргасан.

11. Улсын Их Хурлын байнгын хороонд Эрүүгийн хуулийн 166, 167 дугаар зүйлээр шийтгүүлсэн хүмүүсийн судалгааг гаргаж өгөв.

USAID төслийн удирдагч Гарри Ледбеттерийн хүсэлтийн дагуу “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн ажлын хэрэгцээнд Монгол Улсад гарч байгаа гэмт хэрэг болон түүнтэй холбоотой тоо, баримт мэдээллийг гэмт хэрэг, гэм буруу, хорих ял гэсэн 3 чиглэлээр 24 асуултаар дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж өгөв.



Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэл” төслийн үр дүн, хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргахаар ажиллаж байгаа “Мон-Консалт” ХХК-ийн мониторингийн багт иргэн, эрүү, захиргааны хэргийн 2002-2007 оны эхний хагас жилийн бүх мэдээнүүдийг тус тусад нь гаргаж өгсөн.

### **Бусад ажлын талаар:**

Улсын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн судалгааны төвийн 2010 хүртэл хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, Ерөнхий шүүгчийн 2007 оны 05 сарын 04-ний өдрийн 25 дугаар захирамжаар батлуулж мөрдлөг болгон ажиллаж байна.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс боловсруулсан “Шүүх, шүүгчийн ажлыг дүгнэх журам, аргачлал, маягт”-ын төсөлд санал өгч оролцсон.

“Монголын төр эрх зүй” болон “Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг шинээр тодорхойлж, сэтгүүлийг хэвлүүлж олны хүртээл болгосон.

Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх онол практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, илтгэлийн эмхтгэл хэвлүүлэхээр бэлтгэж байна.

Эрдэм шинжилгээний бага хурал угтаж хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд илтгэлийн уралдаан зарлаж дүгнэв

Эрүү, иргэн, захиргааны хэргийн тогтоол, шийдвэр, магадлалыг бүх гатны шүүхүүдээс цахим болон хуулбараар татан төвлөрүүлж, сонголт хийж, ХЗҮТ-д шилжүүлсэн.

Судалгааны төвийн ажилтнуудаас онол, арга зүй, практикийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл бичиж нийтийн хүртээл болгосон. Үүнд:

1. Судалгааны төвийн захирал Ч.Нямсүрэн: “Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн эрх” үндэсний чуулганд “Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийг байцаан шийтгэх ажиллагаанаас гадна шийдвэрлэж байгаа гадаадын зарим улс орнуудын туршлага” сэдвээр, “Орчин үеийн эрх зүйн харьцуулсан судлалын тулгамдсан асуудал” хуульч, эрдэмтдийн олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд “Эрх зүйн харьцуулсан судлал: объект, судалгааны арга зүйн зарим асуудал” сэдвээр, “Шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх онол практикийн зарим асуудал” эрдэм шинжилгээний бага хуралд “Алтан Ордны улсын шүүх” сэдвээр илтгэл тавьж оролцсон.

2. ахлах шинжээч О.Баттулга: Улс төрийн боловсрол академийн “Шинэ толь” сэтгүүлд “Коррупцын ойлголт, мөн чанар”, Монголын төр эрх зүй сэтгүүлд “Итгэл даах чадвар” гэсэн өгүүлэл бичиж нийтлүүлсэн.

3. шинжээч Ц.Баярмаа: “Өдрийн сонин”-ны 2007 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 244-р дугаарт “Мянган жилийн түүхтэй Унгарын Дээд шүүх”, “Монголын төр эрх зүй” сэтгүүлийн 2007 оны 2-р улирлын дугаарт “Шүүх байгууллагын нэгдсэн систем бүрдэх эх үүсвэр үүссэн үе /1921-1924/”, “Монголын төр эрх зүй” сэтгүүлийн 2007 оны 3-р улирлын дугаарт “Унгар орноос төрсөн сэтгэгдэл” сэдэвт нийтлэл, өгүүлэлүүд бичиж хэвлүүлсэн.

**Дүгнэхэд** Судалгааны төвөөс 2010 оныг дуустал хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, мөрдлөг болгон ажиллаж эхэлжээ. Тус төв шүүхээс хууль тайлбарлах, хэрэглэх онолын болон практик судалгааны арга зүй боловсруулах, “Монголын төр эрх зүй” сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг өөрчлөх, “Шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлах онол практикийн тулгамдсан асуудал” сэдвээр эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан, энэ хүрээнд хууль зүйн их дээд сургуулийн оюутнуудын дунд өгөгдсөн сэдвээр илтгэлийн уралдаан зарлаж дүгнэх гэх зэрэг шинэ хэлбэрийн ажлыг эхлүүлсэн нь сайшаагууштай.

Гэсэн ч судалгааны төвийн залуу ажилтнууд ажилдаа түргэн дадах, суралцах, ирж буй шинэ онд судалгааны төвийн удирдлагаас залуу ажилтнуудыг ажилд нь дадлагажуулах, шүүх эрх мэдлийн салбарын онол, практикийн мэдлэгийг нь дээшлүүлэх шаарлагатай байна. Энэ талаар судалгааны захирал анхаарч ажиллах шаардлагатай байна.

Шүүх, шүүгчдийн дунд явуулсан судалгааны мэдээлэл бүхий асуулгын хуудсыг эргүүлэн төвлөрүүлэх, тэдэнд шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэх, энэ үндсэн дээр дүгнэлт, санал зөвлөмж гаргах чадвар дутмаг байгааг харгалзаж судлаачдын дунд онол, практикийн судалгааны талаарх сургалтыг байнга явуулах шаардлагатай байна.

Цаашид эрдэм шинжилгээ-судалгааны ажилд гүнзгийрэн орж, шүүх, шүүгчдийн өмнө тулгарч байгаа онол практикийн асуудлыг шийдвэрлэхэд тус Судалгааны төвийн үр өгөөжийг дээшлүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

### **Тав. Гадаад арга хэмжээний талаар**

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэр, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх-ахлах референт Н.Долгорсүрэн нар АНУ-ын Муж улсуудын шүүхийн үндэсний төвийн урилгаар 2007 оны 4 дүгээр сарын 1-нээс 16-ны өдрүүдэд АНУ-ын шүүхийн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалттай танилцаж, Ричмондын Их сургуулийн Хуулийн сургууль дээр зохион байгуулагдсан “Хууль дээдлэх ёс” сэдэвт бага хуралд оролцсон байна.

2007 оны 04 дүгээр сарын 29-нөөс 05 дугаар сарын 12-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан тэргүүтэй 10 шүүгчид **Тайваньд** сургалтанд хамрагдав.

2007 оны 05 дугаар сарын 10-наас 25-ны өдрүүдэд Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан тэргүүтэй нийт 25 хүн **БНХАУ**-ын Ардын Дээд шүүхийн дэргэдэх Үндэсний шүүгчдийн академид сургалтанд хамрагдав.

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэр 2007 оны 6 дугаар сарын 02-ны өдөр Ази номхон далайн Ерөнхий шүүгч нарын 12 дугаар бага хуралд оролцож “Монголын шүүхийн өнөөгийн тогтолцоо, Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн талаар” илтгэл тавьсан байна.

Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, шүүгч Л.Бямбаа, А.Доржготов, Д.Тунгалаг, Б.Ундрах нар БНХАУ-ын Хуульчдын нийгэмлэгийн урилгаар тус улсад энэ оны 8 дугаар сарын 1-5-ны хооронд зохион байгуулагдсан Төв Азийн орнуудын хуульчдын их хуралд оролцсон юм.

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан Тайланд улсад 2007 оны 9 дүгээр сарын 30-наас 10 дугаар сарын 5-ны хооронд зохион байгуулагдсан “Хүн худалдах, хүн наймаалах гэмт хэргийн эсрэг” сэдэвт олон улсын бага хуралд оролцох юм.

Улсын Дээд шүүхийн шүүгч Л.Бямбаа тэргүүтэй шүүгчид Япон улсын “Жайка” олон улсын байгууллагаас 2007 оны 10 дугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 14-ний хооронд Токио хотноо зохион байгуулагдаж байгаа “Иргэний хэргийг эвлэрүүлэн зуучлах” сэдэвт сургалт, семинарт оролцжээ.

Улсын Дээд шүүхийн шүүгч Ч.Тунгалаг, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх-ахлах референт Н.Долгорсүрэн нар БНЭУ-д зохион байгуулагдсан Дэлхийн Ерөнхий шүүгчдийн VIII бага хуралд 12 дугаар сарын 3-наас 14-ний өдрүүдэд оролцлоо.

Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан Хууль зүй, дотоод хэргийн яамны “Эрх зүйн чадамжийг дээшлүүлэх” төслийн хүрээнд БНЭУ-ын туршлага судлав.

Улсын Дээд шүүхийн шүүгч Ц.Сумъяа Ханнс-Зайделийн сангийн шугмаар 12 дугаар сарын 6-наас 16-ны өдрүүдэд ХБНГУ-ын Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлаар явав.

### **Зургаа. Сургалт, семинарын талаар**

1 дүгээр сарын 29-ний өдрөөс 2 дугаар сарын 2-ны өдрүүдэд Улсын Дээд шүүх, “Ханнс-Зайдел”-ийн сантай хамтран Анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Тамгын

хэлтэс, албаны дарга нарын 2007 оны нэгдсэн зөвлөгөөнийг “Хууль зүйн үндэсний төв”-д зохион байгуулав.

Энэ өдрүүдэд эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаатай холбоотой сургалт явуулж, мөн Нийслэл, дүүргийн болон сум буюу сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч нарт Улсын Дээд шүүхийн эрүү, иргэний хэргийн танхимууд, Хүний эрхийн үндэсний комисс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан, Үндэсний арбитрын газруудтай хамтран тусгай хөтөлбөрөөр сургалт зохион байгуулжээ.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооноос 2007 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Хүний эрх ба Хүний дархлал хомсдлын вирус, Дархлал олдмол хомсдол” сэдэвт Бага хуралд Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах Б.Цогт, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Б.Чимгээ нарыг оролцуулав.

Иргэний хэргийн танхимын шүүгчид 3 дугаар сарын 16-нд “ИХШХША-ны зарим асуудал” сургалт Төв аймгийн болон Налайх дүүргийн шүүхийн шүүгч, ажилтнуудын дунд сургалт зохион байгуулав.

Улсын Дээд шүүхийн эрүү, захиргааны хэргийн танхимын тэргүүнүүд болон шүүгчид нийт 10 хүн 3 дугаар сарын 19-24-ний өдрүүдэд “Ханнс-Зайдел”-ийн сангийн дэмжлэгтэйгээр ХБНГУ-ын шүүхийн туршлага судлав.

4 дүгээр сарын 20-ны өдөр Иргэний хэргийн танхимын шүүгчид, туслахуудын хамт Хэнтий аймгийн шүүх, Хүний эрхийн үндэсний комисстай хамтран Хэнтий аймгийн шүүхийн болон мөн аймаг дахь сум дундын 1, 2-р шүүх, ажилтнуудад Багануур дүүргийн шүүхийн шүүгч, ажилтнуудад “Шүүх хүний эрхийн баталгаа” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

2007 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Иргэний хэргийн танхимийн шүүгч А.Доржготов “Монголд газар өмчилж, эзэмшиж байсан талаарх түүх эрх зүйн шинжилгээ” сэдвээр Төв аймгийн шүүхийн шүүгч нарт илтгэл тавьж, сургалт явууллаа.

Захиргааны хэргийн танхимын шүүгч Д.Пунцаг Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч, шүүгчийн туслах нарт “Захиргааны хэргийн шүүхийн нотолгооны онол, практикийн асуудал” сэдвээр 2007 оны 5 дугаар сарын 25-ны өдөр хичээл заав.

Авилгын эсрэг хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах талаар 2007 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Улсын Дээд Шүүхийн шүүгч, захиргааны болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажилтнуудад Авилгатай тэмцэх газрын ажилтан ирж сургалт зохион байгуулав.

Нийслэлийн болон дүүргийн шүүхийн шүүгч нарт явуулсан “Иргэний хууль дахь гэрээний эрх зүйн зохицуулалт, хууль хэрэглэх аргачлал” сэдвээр 2007 оны 4 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн 2007 оны 5 дугаар сарын 11-ний өдрийг дуустал нийт 3 долоо хоногийн хугацаатай сургалтыг Улсын Дээд Шүүх болон Нийслэлийн шүүхийн сургалтын танхимд явуулав. Уг сургалтыг Улсын Дээд Шүүхийн иргэний хэргийн танхимын тэргүүн, багш Ц.Амарсайхан, Дээд шүүхийн шүүгч, багш Б.Ундрах нар хамтран явууллаа.

Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн шинэтгэл хөтөлбөрийн төсөлтэй хамтран анхан болон давах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Тамгын хэлтэс, Албаны дарга нарт “Хэргийн хөдөлгөөний менежмент” сэдэвт сургалт семинарыг 6 дугаар сарын 6-наас 8-ны хооронд зохион байгууллаа.

Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академаас шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт Үндсэн хуулийн эрх зүй, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Иргэний эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа сэдвийн доор 2007 оны 06 дугаар сарын 11-нээс 13-ны хооронд сургалт зохион байгууллаа.

Иргэний хэргийн танхим 6 дугаар сарын 22-нд Монголын Үндэсний Арбитртай хамтран “ИХШХША, шүүх арбитрын ажиллагааны харилцан уялдаа холбоо” сургалт Говьсүмбэр, Дорноговь аймгийн шүүхийн шүүгч, ажилтнуудын дунд зохион байгуулжээ.

Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол академи Улсын дээд шүүхтэй хамтран, Дээд шүүх, Нийслэлийн шүүх, Захиргааны хэргийн шүүх, дүүргийн шүүхүүдийн шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт Герман хэлний анхан шатны сургалтыг нэг сарын хугацаатай зохион байгууллаа.

Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын 5 шүүгч 2007 оны 8 дугаар сарын 01-нээс 8 дугаар сарын 05-ны хооронд БНХАУ-ын Сиань хотод болсон “Бүс нутгийн эрх зүйн хамтын ажиллагаа” сэдэвт семинарт оролцоод ирлээ.

Эрүүгийн хэргийн танхимаас Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар сургалтыг 9 дүгээр сард Нийслэлийн шүүхийн шүүгч нарт зохион байгуулав.

Удирдлагын академийн “Төрийн удирдлагаар мэргэшүүлэх дипломын дараахь сургалт”-ын Төрийн захиргааны Менежерийн “Гариг”-ийн сургалтад Ерөнхий шүүгчийн туслах И.Ганбат, Судалгааны төвийн шинжээч Б.Мөнхзул нар амжилттай суралцаж байна.

2007 оны 10 дугаар сарын 02-ний өдөр MCS-ийн 10 жилийн ойд зориулсан “ICT EVOLUTION 2007” үзэсгэлэн семинарт Улсын Дээд шүүхийн компьютер техник хангамжийн асуудал хариуцсан референт Э.Баярбаатар, компьютер программ хангамжийн асуудал хариуцсан шинжээч Б.Эрдэнэбаяр нар оролцсон байна.

Иргэний хэргийн танхим, Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран 10 дугаар сарны 5-нд “Шүүх-хүний эрхийн баталгаа”, “ИХШХША дахь эрхийн баталгаа” сургалтыг Орхон, Булган аймгийн шүүгч, ажилтнуудын дунд зохион байгуулав.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2007 оны 10 дугаар сарын 22-ноос 24-ний хооронд Аймаг, нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн туслах бөгөөд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт “Захиргааны хэргийн хөдөлгөөний стандарт” сэдвээр сургалт явуулсан байна.

Иргэний хэргийн танхим Нийслэлийн шүүхтэй хамт 4 дүгээр сарын 5, 7 дугаар сарын 6, 10 дугаар сарын 19-ний өдрүүдэд “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал” дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулав.

Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сантай хамтран Аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт зориулан 2007 оны 11 дүгээр сарын 20-ноос 23-ны хооронд “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвийн дор сургалт зохион байгуулжээ.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газраас 2007 оны 12 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулагдах “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд мэдээлэл оруулах аргачлал” сэдэвт сургалт семинарт Улсын Дээд шүүхээс Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах зааварлагч Ш.Даваадулам, Компьютерийн техник хангамжийн асуудал хариуцсан референт Э.Баярбаатар нар оролцсон байна.

Удирдлагын академи 2007-2008 оны төрийн удирдлагын Магистрийн “улирал”-ын сургалтад 2 хүнийг хамруулах эрхийн бичгийг олгосны дагуу тус сургуулиас тавьсан шалгаруулах журам, үндсэн болон нэмэлт үзүүлэлтүүдийг хангасан тул Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч Д.Дэлгэрцэцэг, Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч Д.Байгальмаа нар тус тус Удирдлагын академид суралцах эрхийг авчээ.

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

Улирч буй 2007 онд бид нилээд их зүйл хийж амжуулсан ч шинэ 2008 онд түүнээс ч их зүйл хийх шаардлагатай байна.

Улсын Дээд шүүх 2008 онд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

1. Шүүхийн менежментийн үзэл баримтлалд заагдсан шүүхийн эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилтын дагуу хэргийн хөдөлгөөний нэгдсэн стандартыг боловсруулах;

2. Эрүү, Иргэний болон иргэн, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинжлэх ухааны тайлбарыг гаргаж, олон нийтийн хүртээл болгох;

3. Анхан болон давж заалдах шатны шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг эрчимжүүлэх;

4. Шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөө болон шүүгч, ажилтны сахилга, хариуцлага, ёс зүй, ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшинг дээшлүүлэхэд онцгой анхаарах;

5. Шүүгч, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд тэдгээрийг орон сууц худалдан авах урт хугацааны, бага хүүтэй зээлд хамруулах;

Эдгээр зорилтыг шийдвэрлэхийн төлөө хамтран ажиллацгаая.

Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА